

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ ХОРИН НАЙМДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2015 оны аравдугаар сарын 01-ний 14 цаг 04 минутад эхэлж, 15 цаг 32 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг нийт 28 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргах тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none"><li data-bbox="896 1081 1521 1375">1. Лхагваагийн Баатарчулууныг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын дэд даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх<li data-bbox="896 1375 1521 1753">2. Нөөцөд бүртгэгдсэн Лхагваагийн Баатарчулууныг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын дэд даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Хууль зүйн сайд Д.Дорлигжавт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
2	Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн мэргэшлийн хорооны Ажлын албаны	Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их

	<p>даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргах тухай</p>	<p>Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none"> 1. Найдандоржийн Мөнхзул, Жалбаагийн Батмагнай нарыг Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн мэргэшлийн хорооны ажлын албаны даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх 2. Нөөцөд бүртгэгдсэн Найдандоржийн Мөнхзулыг Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн мэргэшлийн хорооны ажлын албаны даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Лүндэндоржид санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
3	<p>Санхүүгийн зохицуулах хорооны зарим албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, тухайн тухайн албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргах тухай</p> <ul style="list-style-type: none"> - Үнэт цаасны зохицуулалтын газрын даргын албан тушаалд томилогдох - Хяналт шалгалтын газрын даргын албан тушаалд томилогдох - Зах зээлийн хөгжлийн газрын даргын албан тушаалд томилогдох - Даатгалын зохицуулалтын газрын даргын албан тушаалд томилогдох 	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none"> 1. Түдэвваанчигийн Гандуламыг Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны зохицуулалтын газрын даргын, Баньдийн Оюунцацралыг Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалтын газрын даргын, Цэрэндоржийн Нацагдоржийг

		<p>Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын зохицуулалтын газрын даргын даргын, Аюушсүрэнгийн Батпүрэв, Доржийн Мөнхзаяа нарыг Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн хөгжлийн газрын даргын албан тушаалд тус тус томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх</p> <p>2. Нөөцөд бүртгэгдсэн иргэдээс Түдэвваанчигийн Гандуламыг Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны зохицуулалтын газрын даргын, Бандийн Оюунцацралыг тус Хорооны Хяналт шалгалтын газрын даргын, Цэрэндоржийн Нацагдоржийг мөн Хорооны Даатгалын зохицуулалтын газрын даргын, Аюушсүрэнгийн Батпүрэвийг Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн хөгжлийн газрын даргын албан тушаалд тус тус томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга Б.Батсэлэнгэд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	<p>УИХ-ын гишүүнээр 1992-2008 онд ажиллаж байсан Ц.Шаравдоржийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17.11, Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Монгол Улсын Их Хурлын гишүүнээр 1992-2008 оны хооронд сонгогдон ажиллаж байсан Цэрэнхүүгийн Шаравдоржийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
5	<p>Орхон аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн</p>	<p>Орхон аймгийн Иргэдийн</p>

	<p>нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын талаар танилцуулах</p>	<p>Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг гурван удаа зарласан ч бүртгэлд хамрагдсан иргэн байхгүй тул Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд албан бичгээр энэ тухай мэдэгдэж, санал авахаар шийдвэрлэлээ.</p>
6	<p>Дорноговь, Говьсүмбэр, Орхон, Дархан-Уул, Дорнод, Баянхонгор зэрэг аймагт зохион байгуулсан нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2015 оны 09 дүгээр сарын 08-19-ний өдрүүдэд Дорноговь аймаг, Говьсүмбэр аймаг, Орхон аймаг, Дархан-Уул аймаг, Дорнод аймаг, Баянхонгор аймагт тус тус зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 10 дугаар сарын 01 -ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Дорноговь аймаг, Говьсүмбэр аймаг, Орхон аймаг, Дархан-Уул аймаг, Дорнод аймаг, Баянхонгор аймагт 2015 оны 09 дүгээр сарын 08-19-ний өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1, 2, 3, 4, 5 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 151 иргэн /Дорноговь аймагт 52, Говьсүмбэр аймагт 24, Дархан-Уул аймагт 13, Дорнод аймагт 33, Баянхонгор аймагт 29/-ийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 6, 7, 8, 9, 10, 11 дүгээр хавсралтад</p>

дурдсан нэр бүхий 102 иргэн /Дорноговь аймагт 7, Говьсүмбэр аймагт 1, Орхон аймагт 7, Дархан-Уул аймагт 34, Дорнод аймагт 29, Баянхонгор аймагт 24/-ийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх

2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 12, 13, 14, 15, 16 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 30 иргэн /Дорноговь аймагт 6, Говьсүмбэр аймагт 4, Дархан-Уул аймагт 5, Дорнод аймагт 5, Баянхонгор аймагт 10/-ийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 17, 18, 19, 20, 21, 22 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 20 иргэн /Дорноговь аймагт 4, Говьсүмбэр аймагт 1, Орхон аймагт 1, Дархан-Уул аймагт 5, Дорнод аймагт 4, Баянхонгор аймагт 5/-ийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх

3. Энэхүү тогтоолын 12-22 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 50 нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Дорноговь аймаг дахь салбар зөвлөл /С.Бөххүү/-д, Төрийн албаны зөвлөлийн Говьсүмбэр аймаг дахь салбар зөвлөл /Б.Батдэлгэр/-д, Төрийн албаны зөвлөлийн Орхон аймаг дахь салбар

		<p>зөвлөл /В.Сумъяасүх/-д, Төрийн албаны зөвлөлийн Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөл /Ч.Чүлтэмбат/-д, Төрийн албаны зөвлөлийн Дорнод аймаг дахь салбар зөвлөл /П.Бат-Өлзий-д, Төрийн албаны зөвлөлийн Баянхонгор аймаг дахь салбар зөвлөл /О.Тойвгоо/-д тус тус үүрэг болгох</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
7	<p>Боловсрол, соёл шинжлэх ухааны яамны Инноваци, өндөр технологийн газрын даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Лхамын Лувсанжамцыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Инноваци, өндөр технологийн газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Ш.Булга-Эрдэнэд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов</p>
8	<p>Төрийн албаны зөвлөлийн Хөдөлмөрийн яамны дэргэдэх салбар зөвлөлөөс зохион байгуулсан Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн захирлын сонгон шалгаруулалтад орсон Д.Очирбатаас гаргасан гомдлыг хянан шийдвэрлэсэн Маргаан хянан шалгах комиссын</p>	<p>Иргэн Д.Очирбатаас Хөдөлмөрийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 13 дугаар тогтоолыг эс зөвшөөрч, Төрийн албаны зөвлөлд гаргасан өргөдөл үндэслэлтэй эсэхийг шалгасан Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг хянан хэлэлцээд,</p>

	дүгнэлтийн тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.5, Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрмийн Хоёрын 2.2.11-т заасныг болон Төрийн албаны зөвлөл 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Хөдөлмөрийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 13 дугаар тогтоолоор Завхан аймаг дахь Тосонцэнгэл сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрийн төвийн захирлын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсэн Рашдаваагийн Балдансамбуу нь уг ажлын байранд тавигдсан мэргэжлийн шаардлыг хангахгүй байна гэсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх</p> <p>2. Хөдөлмөрийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 13 дугаар тогтоолын хавсралтад заасан Рашдаваагийн Балдансамбууг Завхан аймаг дахь Тосонцэнгэл сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрийн төвийн захирлын албан тушаалд нэр дэвшүүлсэн хэсгийг хүчингүй болгохыг Салбар зөвлөлд үүрэг болгох</p> <p>3. Завхан аймаг дахь Тосонцэнгэл сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрийн төвийн захирлын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг 2015 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр баталгаажсан ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтод заасан ерөнхий шаардлагын дагуу сонгон шалгаруулалтыг дахин явуулахыг Хөдөлмөрийн яамны дэргэдэх Салбар зөвлөлд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	------------------	--

